



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№10 /224/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.12

Цаг үе, үйл явдал

ТЭМЦЭЭНИЙ ШИЛДГҮҮД ТОДОРЧ ЭХЛЭЛЭЭ



Агаарын цэргийн командлалын нэрэмжит Зэвсэгт хүчний аварга шалгаруулах Цэрэгжлийн спортын өвлийн 2 төрөлт, ЦСЦ-ын өвлийн олон төрөлтийн тэмцээний хоёр дахь өдрөө Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Сургалтын төвд амжилттай зохион байгуулагдаж байна. Зэвсэгт хүчний 2021-2022 оны биеийн тамир, спортын уралдаан тэмцээний салхийг хагалсан зарим төрлүүдийн шилдгүүд эхнээсээ тодроод байна.

Тухайлбал, Зэвсэгт хүчний 2022 оны аварга шалгаруулах "өвлийн 2 төрөлт"-ийн биатлонд хувийн дүнгээр 1 дүгээр байрт

ахлагч О.Гантулга /337/, 2 дугаар байрт дэслэгч У.Батжаргал /015/, 3 байрт ахлагч Ө.Отгонбаяр /350/ нар тус тус шалгарлаа. Биатлоны багийн дүнгээр 1 дүгээр байрт ахмад Б.Цээноров, ахлагч Ө.Отгонбаяр /350/, 2 дугаар байрт ахлагч Б.Мөнх-Эрдэнэ, Ц.Ганзориг /084/, 3 дугаар байрт ахлагч О.Гантулга, дэд ахлагч Б.Ганхүү /337/ нар шалгарлаа.

Хоёр жилд нэг удаа зохион байгуулагддаг уг тэмцээнд энэ жил Зэвсэгт хүчний 24 нэгтгэл, ангийн 300 орчим тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа сорин оролцож байгаа юм.



ХАМТ ОЛНООРОО НӨХӨРСӨГ ӨДӨРЛӨГТ ОРОЛЦЛОО



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2.267.296 /69.7%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2.166.817 /66.6%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

946.536 29,1%

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
7433 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
192

ЭДГЭРСЭН
7125

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ГАР УРЛАЛЫН СУРГАЛТАД ХАМРАГДАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Ангийн хугацаат цэргийн алба хаагчид энэ сарын 11-ний өдрөөс эхлэн "Гар урлал"-ын сургалтад нэр бүхий 10 байлдагчийг хамруулж эхэлсэн бидний хэлж заншсанаар цагаан ултай гутлыг хийх арга техникийг 1 сарын хугацаанд суралцаж төгсөх бөгөөд сургалтыг ангийн зочид буудлын эрхлэгч Ж.Нарансолонго удирдан заах арга зүй болон практик дадлагыг хослуулан зохион байгуулж эхэллээ.

Уг сургалтын гол зорилго нь хугацаат цэргийн алба хаагчдыг тэсвэр хатуужилтай болгох,

аливаа зүйлд тууштай хандах зан чанарт сургахаас гадна тэдний нийгэмд эзлэх байр суурийг нь чанаржуулах амьдралын ухааныг сургах олон давуу талтай юм.

Тэд Монгол түмний их баяр болох XVII жарны "Сайжруулагч" хэмээх усан Бар жилийн цагаан сарын баяраас өмнө юу сурч мэдсэнээ ангийн удирдлага, нийт алба хаагчид, онжавууддаа "Гар урлал"-ын үзэсгэлэнгээ дэлгэн харуулах бөгөөд эрмүүн их хүсэл тэмүүлэлтэйгээр зорилт тавин суралцаж байна.

Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН



Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Ангийн бие бүрэлдэхүүний дунд "Эрүүл агаар-идэвхтэй хөдөлгөөн" өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгөөр хамт олны нөхөрсөг уур амьсгалыг бэхжүүлэх зорилгоор Елын ам дахь байгалийн музейтэй танилцаж, үзэсгэлэнт Хавцгайтын аманд олс таталт, цасны сумо, уулын оргил булаацалдах тэмцээнүүдийг явуулсан юм.

Олс таталтын тэмцээнд хошууч Б.Гансүх ахлагчтай I баг, цасны сумо тэмцээнд ахмад Б.Бат-Очир, ажилтан албан хаагч Н.Алтаннавч нар, уулын оргил булаацалдах

тэмцээнд дэд ахлагч Мөнх-Оргил, дэд ахлагч Д.Долгорсүрэн, мөс онох тэмцээнд харуулын салааны VI багийн хамт олон бусдыгаа манлайлсан юм.

Дэслэгч Г. НАНДИНЧИМЭГ



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 314,090,366

Эдгэрсэн

Нийт: 261,659,479

Нас барсан

Нийт: 5,521,031

Түүхэнд энэ өдөр

1912 он.

Улиастай хотыг чөлөөлж, Манжийн амбанг хөөв.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-15	-29

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,853.00	2,855.0
EUR	3,235.0	3,245.0
CNY	447.30	448.00
RUB	38.50	39.20
JPY	24.56	24.65
KRW	2.38	2.39

ЗУРХАЙ

2022.01.012 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 10/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:

Эрч хүч ихэснэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.38-17.22

БАРИЛДЛАГА: Үхэх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

САНСАР

Суудал: Шороо

Энэ өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адегус муулах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал арилжих, буг дарах, газрын ам бооход сайн. Эрдэнийг гадагш өгөх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Дашнямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч, хүч нэмнэ.

ДОРНЫН ЗУРХАЙ: Үс засуулбал эрч, хүч нэмнэ

Цахим шууданд

БОДИТ ЦАГИЙН БАЙДАЛД ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГҮҮЛЭВ

Зэвсэгт хүчний 186
дугаар анги

Ангийн 2021-2022
оны сургалтын нэгдсэн
төлөвлөгөөний дагуу
бие бүрэлдэхүүний үүрэг
гүйцэтгэх бэлэн байдлыг
хангаж, сэтгэл зүй, бие
бялдрын бэлтгэлжилтийн
түвшинг дээшлүүлэх, албад
салбаруудын харилцан

ажиллагааг хангах зорилгоор
тактик, тусгай бэлтгэлийн
цогцолбор 30 км-ийн явган
маршийг зохион байгууллаа.

Энэхүү маршаар салаа
салбарын офицеруудыг байр
зүйн зураг дээр ажиллах,
өөрийн байгаа тодорхойлох,
газар орны шинж чанарыг
судлах үүрэг гүйцэтгүүлж,
жижиг бүлгийн тактикийн
ажиллагаагаар "эзлэгдсэн"

газар орныг чөлөөлөхөд
оролцуулсан юм. Мөн энэ
үеэр "Эрдэнэт" ТӨҮГ-ын
ашигт малтмалын хаягдлаас
үүссэн цагаан тоосонцроор
бохирдсон газар орныг
хүн нэг бүрийн хамгаалах
хэрэгсэлтэйгээр 3 км зам
туулсан нь бодит цагийн
байдалд тулгуурласан чухал
даалгавар байж чадлаа.

Ахмад Э.АРИУНТУЯА

БХЭШХ-ИЙН ЭНХИЙГ ДЭМЖИХ ОЛОН УЛСЫН
СУДАЛГААНЫ ТӨВД ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

1. Албан тушаалын зорилго: Энхийн үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэхэд Энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр суурь болон хавсарга судалгаа явуулах, Энхийг дэмжих ажиллагааны хөгжлийн чиг хандлагыг судлах, судалгаа шинжилгээний ажлын үр дүнгээр санал, санаачилга гаргах, бодлогын түвшинд зөвлөмж боловсруулах;

2. Албан тушаалд тавигдах шаардлага:

- Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
- Төрийн албанд 4-өөс доошгүй жил ажилласан байх;
- Англи хэл мэргэжлийн түвшинд эзэмшсэн байх;
- НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн байх.

3. Бүрдүүлэх материал

- Өргөдөл;
- Төрийн алба хаагчийн анкет (1 дүгээр маягтаар);
- Боловсролын зэргийг гэрчилсэн баримт (дипломууд);
- Иргэний болон офицерын үнэмлэхийн хуулбар;
- Цагдаагийн байгууллагын тодорхойлолт;
- Сонгон шалгаруулалтад орохыг зөвшөөрсөн ажиллаж буй байгууллагын бичгээр гарсан зөвшөөрөл;

Бүртгэлийн хураамж (тухай бүрд тогтоон зарлана).

Бүртгэл: 2022 оны 1дүгээр сарын 20-ны өдөр хүртэл ҮБХИС-ийн штабын 3 дугаар давхар, 303 тоот өрөөнд явагдана.

Холбогдох албан тушаалтан: БХЭШХ-гийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, хурандаа Т.Соронзонболд, Эрдэм шинжилгээний ажилтан, дэд хурандаа Т.Мөнх-Оргил Утас: 99065687.

Гэрэл зургийн агшин

Гэрэл зургийг ахлах ахлагч Г.Бат-Эрдэнэ



ЖАНЖИН Д.СҮХБААТАРЫН НЭРЭМЖИТ СҮХБААТАРЫН БА
БАЙЛДААНЫ ГАВЪЯАНЫ БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ
УЛААН ТУГИЙН ОДОНТ

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ
2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ХАВРЫН УЛИРЛЫН
МАГИСТР ДОКТОРЫН ЭЛСЭЛТ

ЭЛСЭЛТ АВАХ ХӨТӨЛБӨР, МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ:

МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР

1. Хуурай замын цэргийн сургалт
2. Агаарын цэргийн сургалт
3. Кибер аюулгүй байдлын цэргийн сургалт
4. Батлан хамгаалах
5. Цэргийн шинжлэх ухаан
6. Аюулгүй байдал судлал
7. Төрийн удирдлага

ДОКТОРЫН ХӨТӨЛБӨР

1. Батлан хамгаалах
2. Цэргийн шинжлэх ухаан
3. Аюулгүй байдал судлал

Бүртгэл: 2022.01.03-аас 2022.01.25-ны ажлын өдрүүдэд 09.00-17.00 цагт бүртгэж байна.

Шалгалт: 2022.01.26 -нд

Холбоо барих: 99092890, 86100101, 94095225

E-mail: *Магистр:* lhbatjargal@gmail.com, *Доктор:* sbolortsetseg22@gmail.com



Дарга, ерөнхий
редактор, хурандаа
САНЖМЯТАВЫН
ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ



Батлан хамгаалах яам



Зэвсэгт хүчний
Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС



"Соёмбо" сонин



"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны
түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх
дүүрэг, Офицеруудын ордон
Индекс: 10018

Цахим шуудан:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)